

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын бүтцийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

2024.07.10

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын яам

*Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09
дүгээр сарын 11-ний өдрийн 380 дугаар
тогтоолоор нэмэлт, өөрчлөлт
оруулсан./*

Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын
Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

*Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09
дүгээр сарын 11-ний өдрийн 381 дүгээр
тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./*

Албан тушаалын нэр:

НҮБ түүний төрөлжсөн байгууллагууд,
олон талт хамтын ажиллагаа хариуцсан
ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-5,
Улаанбаатар-15160

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:


Салбарын асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын салбар байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх, НҮБ-ын гэрээ, конвенц, холбогдох Олон талт гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах, хамтын ажиллагааны бодлогыг төлөвлөж, хэрэгжүүлэх, гадаад арга хэмжээ, ёслол протоколыг гүйцэтгэх арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг газар, хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:


1.НҮБ болон түүний салбар байгууллагатай хамтын ажиллагааны асуудлаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах санал боловсруулж, шийдвэрлүүлэхэд зохицуулалтаар хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

- 2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын асуудлаар НҮБ, түүний салбар байгууллагатай байгуулах гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 3.Салбарын асуудлаар НҮБ-ын холбогдох конвенцын тайланг зохион байгуулах, зохицуулах;
- 4.НҮБ-ын шугамаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангах, зохицуулалтаар хангах;
- 5.Эрхлэх асуудлын хүрээнд Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон холбогдох албан тушаалтнуудын гадаад арга хэмжээнд хамтын ажиллагааны аргазүйн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх;
- 6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх-Г Хянах- Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.НҮБ болон түүний салбар байгууллагатай хамтын ажиллагааны бодлогыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах;	Олон талт гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэл тодорхойлогдож, хамтын ажиллагааны ерөнхий зохицуулалтаар хангагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт НҮБ болон түүний салбар байгууллагатай олон талт гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах асуудлаар холбогдох газар, нэгж, Гадаад харилцааны Яамтай хамтран ажиллах, аргазүйн дэмжлэг үзүүлэх, зохицуулалтаар хангах;	Засгийн газар, байгууллага хоорондын гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулахад зохицуулалтаар хангасан; олон улсын болон Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр нь салбарын бодлогын хэрэгжилтийг дэмжсэн байна.	Г
	2.Эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгүүдийг зохих журмын дагуу бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, архив үүсгэх;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтлөж, архивт хүлээлгэн өгсөн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.НҮБ-ын холбогдох конвенцын хэрэгжилтийн асуудлаарх Засгийн газрын тайланг боловсруулж, холбогдох Хороодод хүргүүлэх болон зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг боловсруулж холбогдох хороодод хүргүүлэхэд зохицуулалтаар хангах;	НҮБ-ын холбогдох Хороодод НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг хүргүүлэхэд болон зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хүргүүлэхэд зохицуулалтаар хангасан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.НҮБ түүний салбар байгууллагуудын шугамаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд хэрэгжүүлж	НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын	Г



	буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулах, холбогдох асуудлаар яамны удирдлага, нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	салбарын бодлого, зохицуулалтыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан байна.	
	2.НҮБ болон түүний салбар байгууллагын шугамаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар яамны удирдлага, нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах;	Олон улсын санхүүгийн байгууллагын зээл, буцалтгүй тусламжаар салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд үр ашигтай, уялдаа холбоотой хэрэгжсэн байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.НҮБ-ын салбар байгууллагуудтай хөгжүүлж буй хамтын ажиллагааны асуудлаар албан тоот, бусад баримт бичгийн төслийг боловсруулах, орчуулах, яамны бусад нэгжээс боловсруулсан баримт бичгийн орчуулгыг хянах;	Төсөл нь үндэслэлтэй, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийцсэн байна.	Г
	2.Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад айлчлалын бэлтгэл ажлыг хангах, айлчлалыг зохион байгуулах;	Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад арга хэмжээ зөв чиглэлд тодорхойлогдож, зохих журмын дагуу явагдсан байна.	Г
	3.Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын өндөр хэмжээний зочид, дипломат төлөөлөгчидтэй хийх уулзалтыг товлох, яриа хэлэлцээний сэдвийг тодорхойлох, зохион байгуулах;	Яриа хэлэлцээний сэдэв нь үндэслэлтэй, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийцсэн байна.	Г
	4.Холбогдох газар, хэлтэст эрхлэх асуудлын хүрээнд арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г
	5.Эрхлэх асуудлын хүрээнд гадаад, хамтын ажиллагаатай холбогдсон албан ёсны арга хэмжээний ёслол, протоколыг хэрэгжүүлэн ажиллах;	Арга хэмжээнүүд дипломат ёслолын албаны дүрэм, журамд нийцсэн байна	Г
	6.Яамны удирдлага НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төлөөлөгчидтэй хийх уулзалтад зохих журмын дагуу оролцож, шаардлагатай бол орчуулгын дэмжлэг үзүүлэх, албан ёсны тэмдэглэл хөтлөх;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах;	Албан тушаалын тодорхойлолт болон нэгжийн төлөвлөгөөтэй уялдсан байна.	Г
	2.Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт,	Тайланг тогтоосон хугацаанд бүрэн, оновчтой тайлагнасан	Г



	арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах;	байна.	
	3.Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, мэргэжил арга зүйгээр хангах;	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна.	Г
	4.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, хариу хүргүүлэх;	Өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэсэн байна.	Г
	5.Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зохион бүрдүүлж буй баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтөлж, архивд хүлээлгэн өгсөн байна.	Г
	6.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	Албан тушаалын чиг үүргээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Олон улсын харилцаа /031202/; - Орон судлал /022203/; - Хэл эзэмшихүй /0231/; - Хэл шинжлэл /023202/; - Гадаад хэл, шинжлэл /023203/; - Гадаад хэлний орчуулга /023101/. 	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээллийг шинжилж, шийдвэр гаргах, үр дагаврыг үнэлэх; - мэдээлэлд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - шийдвэрийн үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнд шинжилгээ хийх; - бусад.



	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх гарц, арга замыг тодорхойлох; - хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, хариу өгөх; - хуульд тогтоомжид нийцсэн санал, зөвлөмж боловсруулах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг өөрөө хариуцах; - удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн туршлага, ур чадвар, мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, хамтран ажиллах; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг сонсож, санал санаачилгыг дэмждэг байх; - асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа маргаан бүхий асуудлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:



-
Нийт:

Бусад харилцах субъект:

1. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, албан хаагчид;
2. Харьяа агентлаг, байгууллагын холбогдох албан тушаалтан;
3. Төрийн бусад байгууллага, холбогдох албан тушаалтан;
4. Иргэн, хуулийн этгээд.



V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.БАТСАЙХАН (Гарын үсэг)(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 04 дугаар сарын 05-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 24 0320 Дугаар: 086
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ Шийдвэрийн огноо: 2024.04.05 Дугаар: 8/82 (тамга/тэмдэг)  ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЛИМАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 04 дугаар сарын 05-ны өдөр	

